



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 07 өдөр

Дугаар А/69

Сүхбаатар сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "г", 30 дугаар зүйлийн 30.1.6, Монгол Улсын Сангийн сайдын 2018 сны 12 дугаар сарын 31-ний өдрийн "Журам шинэчлэн батлах тухай" 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын ивээл дор зохион байгуулагдах Монгол Улсын буудлагын спортын мастер, бэлтгэл дэд хурандаа Д.Ганбаатарын нэрэмжит "Сэлэнгэ аймгийн буудлагын аварга шалгаруулах тэмцээн"-ийг 2019 оны 03 дугаар сарын 13-нд аймгийн төв Сүхбаатар хотод зохион байгуулсугай.

2.Зохион байгуулах ажлыг хэсгийг бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар, тэмцээнд шаардагдах зардлыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Тэмцээний зардалд шаардагдах 1.330.000 /нэг сая гурван зуун гучин мянган/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /О.Мөнхбаяр/-д зөвшөөрсүгэй.


4.Тэмцээний бэлтгэл ажлыг сайтар ханган, осол авааргүй зохион байгуулж, дүн тайланг 2019 оны 03 дугаар сарын 20-ны дотор ирүүлэхийг ажлын хэсгийн ахлагч аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга /Д.Ёндонжамц/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ

Аймгийн Засаг даргын 2019 оны 03 дугаар
сарын 07-ны өдрийн 169 тоот захирамжийн
1 дүгээр хавсралт



ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч:
Д.Ёндонжамц

-Аймгийн Засаг даргын Тамгын
газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Нарийн бичгийн даргаар:
Б.Энхболд

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Цэргийн штабын дарга, дэд хурандаа

Гишүүдэд:

Б.Гантэмөр

-Хилийн 0243 дугаар ангийн захирагч,
хурандаа

В.Намхайнямбуу

-Хилийн 0101 дүгээр ангийн захирагч,
хурандаа

Г.Баатар

-Онцгой байдлын газрын дарга,
хурандаа

А.Энхбат

-Цагдаагийн газрын дарга, хурандаа

Б.Алтангэрэл

-Тагнуулын газрын дарга, дэд хурандаа

Б.Мөнхзул

-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны
дарга, дэд хурандаа

Ч.Дамдинсүрэн

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Цэргийн штабын Орон нутгийн
хамгаалалт, сургалтын офицер, хошууч